



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/157

Баян-Овоо

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.2, 69.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/502 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2024 оны 10 дугаар сарын 10-наас 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд сумын хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийг ажиллуулахыг хориглосугай.

2. Сумын нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч д/ч (Г.Билгүүн), багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000350